



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/74

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын даргын ивээл доор ахлах ангийн сурагчдын санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулж буй “LEVEL-UP” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааны зардалд 1,712,000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 1,712,000 (нэг сая долоон зуун арван хоёр мянга) төгрөгийг Засаг дарга дансны “Мөрийн хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээний зардал” -аас тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Гомбосүрэн) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Баасанхүү)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001-0200

Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 03-ны өдрийн
А/74 дүгээр захирамжийн хавсралт

“LEVEL-UP” ХӨТӨЛБӨРИЙН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Аян рестораны түрээсийн зардал	цаг	2	400,000	800,000
2	Кофе	ш	450	1000	450,000
3	Жигнэмэг	ш	450	500	225,000
4	Шатахууны зардал	л	60	3950	237,000
Дүн					1,71,2000

-oOo-